



ТЗДТБХЗГ-ЫН ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВИЙН  
АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОБЬЕКТ ҮЙЛ  
АЖИЛЛАГААГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГТ

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯМ

УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДУГНЭЛТ

14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
II хороо, Чингисийн өргөн чөлөө 11  
Утас: 62263168, Факс: (976-11) 31-23-15  
И-мэйл: info@mrtd.gov.mn, <https://www.mrtd.gov.mn>

2016. 09. 26 № 88-07-068/03

Г 7

Салбар төмөр замын объектын  
гэрчилгээний тухай

“Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 5<sup>2</sup>, 10 дугаар зүйл, “Төмөр замын тээврийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.6 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.5.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн “УБТЗ” ХНН-ийн Эрдэнэт өртөөнд “Шунхлай Петролиум” ХХК-ийн салбар төмөр замын дэвсгэр зургийг холбогдох баримт бичигтэй тулган шалгаж үзээд дараах дүгнэлтийг гаргав.

**ТОДОРХОЙЛОХ НЬ:**

“УБТЗ” ХНН-ийн Эрдэнэт өртөөн дэх “Шунхлай Петролиум” ХХК-ийн нефтийн бүтээгдэхүүний агуулахын түлш буулгах, ачих зориулалтаар ашиглаж байгаа салбар төмөр зам нь “УБТЗ” ХНН-ийн балансын салбар замын үргэлжлэх хэсэгт хамаарч, нэгдмэл зурагт тусгагдсан бөгөөд ЗТХХ-ийн Төмөр замын тээврийн хяналтаас газар дээр нь дахин нарийн хэмжилт хийж, хил заагийг тогтоож, зураг төслийг дахин шалгах хүртэл тус замыг гэрчилгээжүүлэх боломжгүй байгаа билээ.

Иймд тус замыг гэрчилгээжүүлэх хүртэл /2016.11.01/ “Шунхлай Петролиум” ХХК-ийн Замын 6-р ангитай байгуулсан зам арчлалтын гэрээ, Эрдэнэт өртөөтэй байгуулсан вагон таталт тавилтын гэрээ зэргийг үндэслэн тус байгууллагад тээврийн үйлчилгээг дээр заасан хугацаанд үргэлжлүүлэн үзүүлэхэд татгалзах зүйлгүй байна.

**Хувийг: “УБТЗ” ХНН-ийн Эрдэнэт өртөө, “Шунхлай Петролиум” ХХК-д**

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЗАМЫН ХЯНАЛТЫН  
МЭРГЭЖИЛТЭН, УЛСЫН БАЙЦААГЧ



С.МАЙДАР